Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтэс

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 3.1. | Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | - | - | - | | 1/ Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангах хүрээнд Дэлхийн өв сангаас гаргадаг "Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс", Транспаренси интернэйшнл байгууллагын “Авлигын төсөөллийн индекс”, IMD-ийн "Дэлхийн өрсөлдөх чадварын индекс", Бертельсман сангийн "Шилжилтийн индекс", Дэлхийн банкнаас гаргадаг "Засаглалын үзүүлэлтүүд" зэргийг судалж эдийн засгийн тэргүүлэх чиглэл тодорхойлох суурь судалгааг хийн хувь нэмэр | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оруулсан болно. 2/ Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг гүйцэтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлэх хүрээнд тус хэлтсээс хариуцдаг хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтээр тооцоо, төсөөлөл хийж танилцуулгад тусган ажилласан. Мөн Засгийн газрын хуралдаан, УИХ-аар хэлэлцүүлэхэд удирдлагуудыг мэдээллээр хангаж хэлтсийн хариуцсан асуудлаар шипи боловсруулж ажилласан. 3/ Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн мэдээллийг боловсруулах ажлын хүрээнд тус хэлтсээс хариуцдаг хөдөлмөр эрхлэлт, бизнес регистрийн үзүүлэлтээр тооцоо, төсөөлөл хийж танилцуулгад тусган ажилласан. Мөн Засгийн газрын хуралдаан, Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхэд удирдлагуудыг мэдээллээр | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хангаж хэлтсийн хариуцсан асуудлаар шипи боловсруулж, холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Түүнчлэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг дахин өргөн барьсантай холбоотойгоор холбогдох танилцуулга, шипид мэдээллийг шинэчлэн боловсруулж тусгаад байна. | | |
| 3.1.1 | Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана. | Үйл ажиллагааны зардлаар | Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө" батлуулсан. | - | Монгол Улсын 2025 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж танилцуулсан байна. /1 танилцуулга / | Олон улсад зарлагддаг, нэр хүнд бүхий индексүүдийг судалснаар тухайн орны дэлхийн улс орнуудын дунд хэрхэн эрэмбэлэгдэж, ямар үзүүлэлтээр сул байгаа, ямар үзүүлэлтээр давуу байгааг харах боломжийг олгодог. Ингэснээр ямар үзүүлэлт, цаашлаад салбар, чиглэлийг илүү анхаарч сайжруулах шаардлагатайг тодорхойлоход хэрэгцээтэй мэдээллийг олж авч болдог. Энэ хүрээнд Дэлхийн өв сангаас гаргадаг "Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс", Транспаренси интернэйшнл байгууллагын "Авлигын төсөөллийн индекс", IMD-ийн "Дэлхийн өрсөлдөх чадварын индекс", Бертельсман сангийн "Шилжилтийн индекс", Дэлхийн банкнаас гаргадаг "Засаглалын үзүүлэлтүүд" зэргийг судалж эдийн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | засгийн тэргүүлэх чиглэл тодорхойлох суурь судалгааг хийн хувь нэмэр оруулсан болно. Хавсралт: 2 файл | | |
| 3.1.2 | Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг гүйцэтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө" батлуулсан. | - | Эдийн засгийн 2025 оны тооцоо төсөөлөл, танилцуулга бэлтгэх /1 танилцуулга/ | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулах хүрээнд тус хэлтсээс хариуцдаг хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтээр тооцоо, төсөөлөл хийж танилцуулгад тусган ажилласан. Мөн Засгийн газрын хуралдаан, УИХ-аар хэлэлцүүлэхэд удирдлагуудыг мэдээллээр хангаж хэлтсийн хариуцсан асуудлаар шипи боловсруулж ажилласан. Хавсралт: 1 файл | 100% | 100 % |
| 3.1.3 | Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг | Үйл ажиллагааны зардлаар | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсан. | - | Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2025 оны тооцоо, төсөөлөл, тэргүүлэх чиглэлийн танилцуулгыг боловсруулсан байна/ 1 танилцуулга/ | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн мэдээллийг боловсруулах ажлын хүрээнд тус хэлтсээс хариуцдаг хөдөлмөр эрхлэлт, бизнес регистрийн үзүүлэлтээр тооцоо, төсөөлөл хийж танилцуулгад | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | | | | | | тусган ажилласан. Мөн Засгийн газрын хуралдаан, Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхэд удирдлагуудыг мэдээллээр хангаж хэлтсийн хариуцсан асуудлаар шипи боловсруулж, холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Түүнчлэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг дахин өргөн барьсантай холбоотойгоор холбогдох танилцуулга, шипид мэдээллийг шинэчлэн боловсруулж тусгаад байна. Хавсралт: 2 файл | | |
| 3.2. | Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлно. | Үйл ажиллагааны зардлаар | - | - | - | | Макро эдийн засгийн судалгааны хүрээнд 2023 оны 4 дүгээр улирал, 2024 оны 1-3 дугаар улирлын нөхцөл байдлыг шинжилж, танилцуулга боловсруулсан. Үүнд Авлигын төсөөллийн индекс, Ардчиллын индекс, Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан, Бертелсманны Шилжилтийн индекс, Өв уламжлалын сангийн Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс, Засаглалын үзүүлэлтүүд, Фрэйзэр институтийн Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн Монгол Улсын үнэлгээ, чиг хандлагыг тодорхойлж, хөдөлмөр | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрхлэлт, аж ахуйн нэгжийн тоо, борлуулалтын орлогын мэдээлэлд шинжилгээ хийв. Богино, дунд хугацааны макро эдийн засгийн загваруудыг хөгжүүлэх хүрээнд Тооцоолох Ерөнхий Тэнцвэрийн Загвар ашиглан шууд татварын хувь хэмжээг 1 хувиар бууруулахад үзүүлэх нөлөөллийг тооцоолж, олон улсын худалдааны GTAP загвараар БНСУ, Евразийн эдийн засгийн холбоо, БНХАУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах эдийн засгийн нөлөөллийг үнэлэв. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэлд суурилсан шинжилгээг сар бүрийн Макро эдийн засгийн тайланд тусгав. Монгол Улсын эдийн засгийн эрсдэлийг тодорхойлох хүрээнд эрчим хүчний тасалдал, зуд, ган, геополитикийн тогтворгүй байдал, экспортын түүхий эдийн үнийн бууралт, нийлүүлэлтийн тасалдал зэрэг эрсдэлийг судалж, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг болон төсвийн тухай хуулийн танилцуулгад тусгасан. НӨАТ болон бизнес регистрийн дата баазад суурилсан мэдээллийн сан | | |

126

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үүсгэж, аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын улирал, сарын давтамжтай мэдээллийг боловсруулсан. Эдийн засгийн урт хугацааны хандлагын судалгаанд хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал, цаашдын хандлагыг тооцоолж, тайланд тусгасан болно. Эдгээр үйл ажиллагаа нь эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын суурийг бүрдүүлэв. | | |
| 3.2.1 | Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macro diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулж, танилцуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Дүн шинжилгээний тоо | Өмнөх онуудын эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн. | - | 2024 оны түвшинд дүн шинжилгээ хийж танилцуулсан байна. /хийсэн тухай бүрийн танилцуулга/ | Макро эдийн засгийн 2023 оны 4 дүгээр улирал, 2024 оны 1-3 дугаар улирлын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулахад "Олон улсад зарлагдсан индексүүд" болон "Хөдөлмөр, аж ахуйн нэгж" бүлгүүдийг бичсэн. Үүний хүрээнд, олон улсад шинэчлэгдэн зарлагдсан Авлигын төсөөллийн индекс, Ардчиллын индекс, Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан, Бертелсманны Шилжилтийн индекс, Өв уламжлалын сангийн Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс, Засаглалын үзүүлэлтүүд, Фрэйзэр институтийн Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексүүдийн Монгол Улсын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үнэлгээ болон олон улсын чиг хандлагад шинжилгээ хийж тайланд тусгав. Түүнчлэн ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлт, цалингийн үзүүлэлтүүд, аж ахуйн нэгжийн тоо, аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын дата мэдээлэлд тооцоо шинжилгээ хийж тайланд тусгаад байна. Хавсралт: 3 файл | | |
| 3.2.2 | Макро эдийн засгийн богино, дунд хугацааны загваруудыг хөгжүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөлд ашиглана. | Үйл ажиллагааны зардлаар | Хөгжүүлсэн загварын тоо | Мэдээллийн дата баазыг бүрдүүлж, туршилт тооцооллуудыг гүйцэтгэсэн. | - | Загвар хөгжүүлсэн байна /1 загвар/ | "МУ-ын эдийн засагт шууд татварын хувь хэмжээг 1 хувиар бууруулахад үзүүлэх нөлөөллийг Тооцоолох Ерөнхий Тэнцвэрийн Загвар (CGE Model) хөгжүүлж тооцооллыг хийсэн. Суурь тоон өгөгдөл болох 2018 оны Нийгмийн тооцооллын матриц дахь өрхүүдийн орлогыг ӨНЭЗС-аас тооцон 5 бүлэгт хувааж задлан шинжилсэн. Түүнчлэн БНСУ, Евроазийн эдийн засгийн холбоо, БНХАУ-тай байгуулах Чөлөөт худалдааны хэлэлцээр болон Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулахад шаардлагатай эдийн засгийн нөлөөллийн үнэлгээг олон улсын худалдааны GTAP загвар ашиглан тооцож үр дүнг боловсруулсан." | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.3 | Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана. | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллийн тоо /Тоо/ | Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн. | - | Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/ | Тус газраас макро эдийн засгийн сарын мэдээний танилцуулгыг боловсруулан бэлтгэж байна. Энэ хүрээнд олон нийтэд нээлттэй байдаг тоо, мэдээллийг ашиглан тооцоо, шинжилгээ хийж олон нийтэд хүргэх хувилбарыг яамны албан ёсны цахим хуудасны https://med.gov.mn/monthlyreport холбоост болон Macro channel нэртэй вайбэр суваг үүсгэн англи болон монгол хэлээр байршуулж ажиллаж байна. Мөн дотоодын байгууллагуудаас тоо, мэдээлэл нэмэлтээр авч яамны удирдлагуудад зориулсан дэлгэрэнгүй хувилбарыг А5 хэмжээтэй товхимол болгон хэвлэж гаргадаг бөгөөд мөн адил англи, монгол хувилбараар бэлтгэж байна. Макро эдийн засгийн сарын мэдээний дээрх хоёр хувилбарт тус хэлтсээс хариуцан ажилладаг хөдөлмөрийн зах зээлийн тоо, мэдээлэлд суурилсан тооцоо, шинжилгээг тухай бүр танилцуулгад оруулдаг бол яамны удирдлагуудад зориулсан хувилбарт НӨАТ-ын мэдээллийн сангийн аж ахуйн нэгжийн борлуулалтын мэдээлэлд тооцоо, | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шинжилгээ хийж сар бүр оруулж ажиллаж байна. Түүнчлэн тус хэлтэс сарын мэдээний танилцуулгыг яамны цахим хуудас болон Вайбэр сувагт байршуулж олон нийтэд түгээх ажлыг гүйцэтгэж байна.<br>Хавсралт: 5 файл | | |
| 3.2.4 | Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангана. | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээллийн тоо /Тоо/ | Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн. | - | Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/ | Power BI ашиглан өдөр тутмын зах зээлийн мэдээллийг тухай бүрд нь шинэчлэн удирдлагыг мэдээллээр ханган ажилласан. Үүнд, нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, газрын тосны тухайн өдрийн, сарын дундаж, сүүлийн 7 хоногийн дундаж экспортын хэмжээ болон хилийн үнэ, Тяньжин боомт дээрх чингэлгийн тоо, импортын тоо хэмжээ, дүн, бараа бүтээгдэхүүний өдөр тутмын мэдээллээр хангаж байна.<br>Хавсралт: 3 файл | 100% | 100 % |
| 3.2.5 | Монгол Улсын эдийн засгийн эрсдэлийг тодорхойлж дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг болон төсвийн тухай хуулийн | Үйл ажиллагааны зардлаар | Эдийн засгийн эрсдэлийг тодорхойлсон танилцуулгын тоо | Эдийн засгийн болзошгүй эрсдэлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн. | - | Болзошгүй эрсдэлийн судалгааг боловсруулж, бодлогын баримт бичгүүдийн танилцуулгад тусгасан | Монгол Улсын эдийн засгийн болзошгүй эрсдэлийг судалж 1/ эрчим хүчний тасалдал, 2/ зуд, ган, мал амьтны өвчин, 3/ экспортын түүхий эдийн үнийн бууралт, 4/ геополитикийн тогтворгүй байдал, 5/ нийлүүлэлтийн тасалдлын хүрээнд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | танилцуулгад тусгана. | | | | | байна./2 танилцуулга/ | тодорхойлж 2025 оны жилийн төлөвлөгөө, 2025 оны төсвийн тухай хуулийн танилцуулгад Эрсдэлийн хэсэгт тусгасан болно. Хавсралт: 3 файл | | |
| 3.2.6 | Дата баазууд боловсруулж эдийн засгийн судалгаанд ашиглана. (Гаалийн дата, И-баримт гэх мэт) | Үйл ажиллагааны зардлаар | Тайланд ашигласан тоо | - | - | Улирлын тайланд ашигласан байна. /3 удаа/ | НӨАТ-ын дата баазад суурилж аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын сар, улирлын давтамжтай дата, мэдээллээр мэдээллийн сан үүсгээд байна. Түүнчлэн Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн улирал, жилийн мэдээллээр дата бааз үүсгэсэн. Мөн засаглал, нийгэм, эдийн засаг, хөгжил, дэд бүтцийн 93 олон улсын индексээрх Монгол Улсын үнэлгээ, эрэмбийн цагийн цувааны дата бааз үүсгээд байна. Гааль, И-баримтын датаг сар бүрд тогтмол авч аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого, НӨАТ-ын шивсэн баримтын тоонд тооцоо, судалгаа хийж макро эдийн засгийн улирал, сар тутмын танилцуулгад оруулж, удирдлагыг холбогдох мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. Хавсралт: 3 файл | 100% | 90% |
| 3.2.7 | Эдийн засгийн урт хугацааны | Үйл ажиллагаан | Судалгааны тоо | Судалгаанд шаардлагата | - | Судалгаа боловсруулса | Эдийн засгийн урт хугацааны хандлагын судалгаанд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хандлагын судалгааг боловсруулна. | ы зардлаар | | й тоон мэдээллийг цуглуулсан. | | н байна. /1 судалгаа/ | хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдлыг нарийвчлан тодорхойлж гол үзүүлэлтүүдийг үнэлэн дүн шинжилгээ хийсэн. Үүний хүрээнд ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшин зэрэг үзүүлэлтүүдийн хандлагыг тооцоолж цаашид гарч болзошгүй өөрчлөлтүүдийг урьдчилан боловсруулсан. Тайлангийн үр дүнгээс дурдвал: Урт хугацааны хандлагаар ажиллах хүчний оролцоо болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин дэлхийн санхүүгийн хямрал, Ковид-19 цар тахлын үеэр буурсан ч эдийн засгийн сэргэлттэй уялдан өсөх төлөвтэй байна. Энэхүү өсөлтөөс шалтгаалан ойрын жилүүдэд хөдөлмөрийн зах зээл тэлж, 2024 оны 3 дугаар улиралд ажиллах хүчний оролцооны түвшин 63 хувьд хүрсэн ч ажилгүйдэл 6.1 хувь болж өссөн байна. Мөн ажилгүйдлийн түвшин урт хугацааны хандлагаас буурч, 2023 онд 5.3 хувь болж эерэг өөрчлөлт ажиглагдаж байна.<br>Хавсралт: 1 файл | | |
| 3.3. | Дунд хугацааны төсвийн хүрээний | Үйл ажиллагаан | - | - | - | | 1/ Эдийн засгийн богино хугацааны идэвхжилийн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлнэ. | ы зардлаар | | | | | тайланг зээл, хөдөлмөр, аж ахуйн нэгжийн төлөв байдал, нийцэлд тооцоо, судалгаа хийж боловсруулсан. 2/ Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах хүрээнд тус хэлтсээс хариуцдаг хөдөлмөр эрхлэлт, бизнес регистрийн үзүүлэлтээр тооцоо, төсөөлөл хийж танилцуулгад тусган ажилласан. Мөн Засгийн газрын хуралдаан, Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхэд удирдлагуудыг мэдээллээр хангаж хэлтсийн хариуцсан асуудлаар шипи боловсруулж, холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Тус хууль 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан болно. Түүнчлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийг дахин өргөн барьсантай холбоотойгоор холбогдох танилцуулга, шипид мэдээллийг шинэчлэн боловсруулж тусгаад байна. | | |
| 3.3.1 | Эдийн засгийн богино хугацааны идэвхжилийн тайлан бэлтгэж удирдлагад | Үйл ажиллагаан ы зардлаар | Тайлангийн тоо | Тайланд шаардлагатай судалгааны тоон мэдээллийг | - | Тайлан боловсруулсан байна. /1 тайлан/ | Эдийн засгийн богино хугацааны идэвхжилийн тайланг зээл, хөдөлмөр, аж ахуйн нэгжийн төлөв байдал, нийцэлд тооцоо, судалгаа | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | танилцуулна. | | | цуглуулсан. | | | хийж боловсруулсан. Тайлангийн голлох үр дүнгээс дурдвал: Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд сайжирч, хөдөлмөрийн зах зээл тэлж буй нь иргэд болон өрхийн орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийн идэвхжилийг дэмжих гол хүчин зүйл болж байна. Үүний үр дүнд хөдөлмөр эрхэлж буй иргэдийн цалин, ахмад настнуудын тэтгэвэр, нийгмийн хамгааллын хүрээнд олгогдож буй тэтгэмжийн хэмжээ нэмэгдсэн нь өрхийн санхүүгийн чадамжийг дээшлүүлж, хэрэглээ өсөхөд эерэг нөлөө үзүүлж байна. Өрхийн хэрэглээний өсөлт нь эцсийн дүндээ эдийн засгийн дотоодын эрэлт, хэрэглээг тэтгэж, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг өргөжүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Мөн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа идэвхжиж, шинээр байгуулагдаж буй аж ахуйн нэгж, бизнесийн тоо өсөх хандлагатай байна. Үүнийг даган иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагуудын зээлийн өсөлт эрчимжиж, санхүүгийн хүртээмж сайжирч байгаа нь бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлж, эдийн засгийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дотоодын эрэлт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд хөдөлмөр эрхлэлт, өрхийн хэрэглээ, бизнесийн идэвхжил зэрэг эдийн засгийн суурь үзүүлэлтүүд сайжирч байгаа нь дотоодын эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлж байна. Хавсралт: 1 файл | | |
| 3.3.2 | Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсан. | - | Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2024-2027 оны тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулсан байна/ 1 танилцуулга/ | Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах хүрээнд тус хэлтсээс хариуцдаг хөдөлмөр эрхлэлт, бизнес регистрийн үзүүлэлтээр тооцоо, төсөөлөл хийж танилцуулгад тусган ажилласан. Мөн Засгийн газрын хуралдаан, Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхэд удирдлагуудыг мэдээллээр хангаж хэлтсийн хариуцсан асуудлаар шипи боловсруулж, холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Тус хууль 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан болно. Түүнчлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийг дахин өргөн барьсантай холбоотойгоор | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбогдох танилцуулга, шипид мэдээллийг шинэчлэн боловсруулж тусгаад байна. | | |
| 3.4. | Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор судалгаа, шинжилгээнд үндэслэн бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана. | Үйл ажиллагааны зардлаар | - | - | - | | 1/ Өв уламжлалын сангийн "Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс"-ийн үзүүлэлтүүдийн дата мэдээллийг цуглуулан нэгтгэж, дүн шинжилгээ хийж дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэн, удирдлагуудад танилцуулж ажилласан. 2/ Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс, Дэлхийн өрсөлдөх чадварын индекс, Авлигын төсөөллийн индекс, Бертельсманны шилжилтийн индекс зэрэг олон улсын голлох индексүүдийн үзүүлэлтүүдийн дата мэдээллийг нэгтгэн боловсруулж, эрэмбэ байрыг ахиулах боломжийг судлан, санал бэлтгэж танилцуулгад тусган удирдлагад танилцуулав. Үнэлгээг сайжруулах чиглэлээр бодлогын санал, зөвлөмжүүдийг тодорхойлж, хөгжлийн төлөвлөгөө, төсвийн бодлогын баримт бичигт тусгасан. 3/ Олон нийтэд мэдээлэл хүргэх хүрээнд Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадвар, | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг хэмжиж буй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн голлох индексүүдийн аргачлал, хэмжиж буй үзүүлэлтүүд, Монгол Улсын авч буй оноо, эрэмбийн талаар мэдээ мэдээллийг тухай бүрд нь шинэчлэн бэлтгэж яамны цахим хаяг болон веб хуудаст тогтмол байршуулж байна. Үүний хүрээнд 2024 оны эхний хагаст Өрсөлдөх чадварын индекс, Авлигын төсөөллийн индекс, Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн 2024 оны үнэлгээ, Монгол Улсын авч буй оноо, эрэмбийн талаар мэдээ мэдээллийг тус яамны веб хуудасны "Эдийн засгийн тойм блог" цэст байршуулав. Түүнчлэн тус газраас боловсруулж, олон нийтэд нээлттэй байршуулж, бодлогын шийдвэр гаргагч байгууллагуудад тараадаг Макро эдийн засгийн 2023 оны 4 дүгээр улирал, 2024 оны 1-3 дугаар улирлын тайланд "Олон улсад зарлагдсан индексүүд"-ийн дэд бүлгийг бэлтгэн оруулсан. Тайланд Авлигын төсөөллийн индекс, Ардчиллын индекс, Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан, Бертелсманны Шилжилтийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | индекс, Өв уламжлалын сангийн Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс, Засаглалын үзүүлэлтүүд, Фрэйзэр институтийн Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексүүдийн Монгол Улсын үнэлгээ болон олон улсын чиг хандлагад шинжилгээ хийж оруулаад байна. | | |
| 3.4. 1 | Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг Өв уламжлалын сангаас гаргадаг "Эдийн засгийн эрх чөлөөний байдлын индекс"-т тулгуурлан судалж шаардлагатай тоо, мэдээллийг цуглуулан сан үүсгэж дүн шинжилгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Өгөгдлийн сангийн тоо | - | - | Өгөгдлийн сан үүсгэсэн байх /1 файл/ | Өв уламжлалын сангийн "Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс"-ийн үзүүлэлтүүдийн дата мэдээллийг цуглуулан нэгтгэж, дүн шинжилгээ хийж дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэн, удирдлагуудад танилцуулж ажилласан. Хавсралт: 2 файл | 100% | 100 % |
| 3.4. 2 | Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр санал боловсруулж танилцуулга бэлтгэн удирдлагад танилцуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Танилцуулгын тоо | - | - | Танилцуулга боловсруулсан байна. /1 танилцуулга/ | Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс, Дэлхийн өрсөлдөх чадварын индекс, Авлигын төсөөллийн индекс, Бертельсманны шилжилтийн индекс зэрэг олон улсын голлох индексүүдийн үзүүлэлтүүдийн дата мэдээллийг нэгтгэн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулж, эрэмбэ байрыг ахиулах боломжийг судлан, санал бэлтгэж танилцуулгад тусган удирдлагад танилцуулав. Үнэлгээг сайжруулах чиглэлээр бодлогын санал, зөвлөмжүүдийг тодорхойлж, хөгжлийн төлөвлөгөө, төсвийн бодлогын баримт бичигт тусгасан. Хавсралт: 1 файл | | |
| 3.4.3 | Эдийн засгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийг сайжруулах чиглэлээр олон нийтэд үнэн, зөв мэдээлэл хүргэж ажиллана. | Үйл ажиллагааны зардлаар | Олон нийтэд хүргэсэн мэдээллийн тоо | - | - | Олон нийтэд мэдээлэл хүргэсэн байна. /1 нийтлэл/ | Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадвар, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг хэмжиж буй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн голлох индексүүдийн аргачлал, хэмжиж буй үзүүлэлтүүд, Монгол Улсын авч буй оноо, эрэмбийн талаар мэдээ мэдээллийг тухай бүрд нь шинэчлэн бэлтгэж яамны цахим хаяг болон веб хуудаст тогтмол байршуулж байна. Үүний хүрээнд 2024 оны эхний хагаст Өрсөлдөх чадварын индекс, Авлигын төсөөллийн индекс, Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн 2024 оны үнэлгээ, Монгол Улсын авч буй оноо, эрэмбийн талаар мэдээ мэдээллийг тус яамны веб хуудасны "Эдийн засгийн тойм блог" цэст байршуулав. | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Түүнчлэн тус газраас боловсруулж, олон нийтэд нээлттэй байршуулж, бодлогын шийдвэр гаргагч байгууллагуудад тараадаг Макро эдийн засгийн 2023 оны 4 дүгээр улирал, 2024 оны 1-3 дугаар улирлын тайланд "Олон улсад зарлагдсан индексүүд"-ийн дэд бүлгийг бэлтгэн оруулсан. Тайланд Авлигын төсөөллийн индекс, Ардчиллын индекс, Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан, Бертелсманны Шилжилтийн индекс, Өв уламжлалын сангийн Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс, Засаглалын үзүүлэлтүүд, Фрэйзэр институтийн Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексүүдийн Монгол Улсын үнэлгээ болон олон улсын чиг хандлагад шинжилгээ хийж оруулаад байна.<br>Хавсралт: 6 файл | | |

*Үнэлсэн:* *И.Батхүү*

*Төрийн нарийн бичгийн дарга* ........................ */И.Батхүү/*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

*2024.12.18*

(огноо)

Тайлагнасан: Ц.Мөнхдэлгэр

ЭЗЭЧӨЧСХ-ийн даргын АҮТОГ .................... /Ц.Мөнхдэлгэр/

(албан тушаал ) (гарын үсэг)

2024.12.18

(огноо)